

БАТЛАВ

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Я.ОЮУН-ЭРДЭНЭ

БАТЛАВ

ХУУЛЬ ГҮЙ, ДЭВСГЭРГИЙН
САЙД И.НЯМДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ
УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд Захиргааны ерөнхий хуулийг баталж, 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн болно.

Дээрх хуулийг мөрдөж эхэлснээр Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно:" гэж, мөн зүйлийн 5.1.1 дэх заалтад "нутгийн өөрөө удирдах байгууллага болон шийдвэр, үйл ажиллагаанд нь захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргахаар хуульд тусгайлан заасан байгууллага." гэж, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад "Захиргааны байгууллага" гэж Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд заасан байгууллагыг" ойлгоно гэж тус тус заасан байдаг.

Улмаар Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэгт "Захиргааны хэм хэмжээний актыг хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага батална." гэж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9 дэх заалтад баг, хорооны Хурал "хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлэх;" гэж, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт сум, дүүргийн Хурал "Хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлнэ." гэж, мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт "Аймаг, нийслэлийн Хурал нь харьяалах нутаг дэвсгэртээ энэ хуулийн 18 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:" гэж тус тус заасны дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас нийтээр дагаж мөрдүүлэхээр захиргааны хэм хэмжээний акт баталсан тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн зургаадугаар бүлэгт заасан үйл ажиллагааг хийж, мөн хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэгт "Захиргааны хэм хэмжээний актыг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актыг

эмхэтгэл"-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ." гэж заасны дагуу тэдгээр шийдвэрийг дагаж мөрдүүлэх учиртай.

Түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн эсэх тухай маргаан гаргасныг Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар 2019 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр авч хэлэлцээд 04 тоот дүгнэлт гаргасан байна.

Дүгнэлтэд "Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9 дэх заалтад "хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлэх;" гэж, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт "Хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлнэ." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно." гэснийг зөрчөөгүй байна." гэж үзсэн байдаг.

1.2. Практик шаардлага

Захиргааны ерөнхий хуулийг нэг мөр хэрэглэх явцад нутгийн өөрөө удирдах байгууллагаас баталсан захиргааны хэм хэмжээний актыг батлах тусгайлсан эрхийг холбогдох хуулиар олгоогүй байхад хуулиас давсан дүрэм, журмыг батлан улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхтэй холбоотой хүндрэлтэй асуудлууд үүсэж байна.

Өөрөөр хэлбэл Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэлд тулгамдаж буй олон асуудлыг шийдвэрлэхийн тулд холбогдох хуулиар уг журмыг батлах тусгайлсан эрх олгогдоогүй байхад Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно." гэж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт "Сум, дүүргийн Хурал нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, дээд шатны Хуралд болон төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хуулиар харьяалуулснаас бусад тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхтэй бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж хэрэгжүүлнэ:" гэж, мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт "Аймаг, нийслэлийн Хурал нь харьяа нутаг дэвсгэртээ энэ хуулийн 18

дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:" гэж, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтад Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын Тэргүүлэгчид "хуульд өөрөөр заагаагүй бол нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх;" гэж тус тус заасан ерөнхий зохицуулалтыг үндэслэл болгон баталж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр ирүүлж байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн 59 дүйлийн 59.1 дэх хэсгийн "Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно." гэж, мөн хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэгт "Захиргааны хэм хэмжээний актыг хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага батална." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Тухайлбал, Худалдаа үйлчилгээний харилцааг зохицуулсан салбарын хууль байхгүй байхад нийслэлийн худалдаа, үйлчилгээний газруудын тоо жилээс жилд өсөж, 2018 оны жилийн эцсийн байдлаар худалдааны 6607, хоол үйлдвэрлэл үйлчилгээний 3540, ахуй үйлчилгээний болон бусад үйлчилгээний 3652, нийт 13799 газар дур зоргоороо үйл ажиллагаа явуулж байгааг цэгцлэх зорилгоор Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 6 дугаар сарын 6-ний өдрийн 25/20 дугаар тогтоолын хавсралтаар "Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам", мөн Нийслэлийн Цагдаагийн газрын Мөрдөн шалгах газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Онцгой байдлын газраас нийтийн байрны үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, нийтийн байранд амьдарч байгаа болон хөдөө орон нутгаас түр оршин сууж буй иргэдийн бүртгэл судалгааг гаргах, татварт хамруулах, сэжигтэй эрэн сурвалжилж байгаа этгээдүүдийг олж тогтоох, галын аюулгүй байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон орон байрны ариун цэвэр норм, стандартыг бүрдүүлэхээр Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа нийт 649 нийтийн байранд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах цэгцлэх зорилгоор Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 163 дугаар тогтоолын хавсралтаар "Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн байрны үйлчилгээ эрхлэхэд мөрдөх журам"-ыг тус тус баталж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр тус яаманд удаа дараа ирүүлээд байна.

Хэдийгээр дээрх журмаар зохицуулж байгаа харилцаа нь Улаанбаатар хотод үүсээд байгаа олон асуудлыг зохицуулахаар байгаа боловч Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэгт зааснаар уг журмыг батлах эрх хэмжээг холбогдох хуулиар нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд олгоогүй байгаа тохиолдолд уг журмыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх хууль зүйн боломжгүй байна.

Түүнчлэн хуулийн дээрх заалтын дагуу Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 6 дугаар сард баталсан "Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам"-ыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгээгүйгээс тус Хурлын Тэргүүлэгчдээс 2014 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журам" үйлчилж, уг журмыг дагаж мөрдөөгүй иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулиар торгууль, шийтгэл оногдуулах асуудал өдөр тутамд үргэлжилсээр байгааг эсэргүүцсэн худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн өлсгөлөн зарлах, эрх олгогдоогүй журмыг бүртгэх асуудлаар төрийн байгууллагуудад удаа дараа шаардлага ирүүлэх зэргээр хандсаар байна.

Иймд орон нутгийн хэмжээнд дээрх журмуудыг батлах эрх хэмжээг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тусгайлан олгох зайлшгүй шаардлагатай байгаа тул хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэрээр боловсруулна. Хуулийн төсөлд дараах зарчмын асуудлыг тусган боловсруулна.

Хуулийн төсөл 3 зүйлтэй байх бөгөөд аймаг, нийслэлд "Худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа, үйлчилгээ эрхлэхэд тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн эрх, үүргийг тодорхойлсон нийтлэг журам" батлах эрхийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоодог байхаар тусгана.

Түүнчлэн "Худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа, үйлчилгээ эрхлэхэд тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн эрх, үүргийг тодорхойлсон нийтлэг журам"-ын хэрэгжилтийг хангуулах чиг үүрэг бүхий "Худалдаа, үйлчилгээний зохицуулах зөвлөл"-ийг сум, дүүргийн Засаг даргын дэргэд ажиллахаар тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар худалдаа, үйлчилгээ эрхлэх болон нийтийн байрны үйл ажиллагаа хуулийн дагуу явах боломж бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн төрөөс хүний эрх, эрх чөлөөний баталгааг бүрдүүлж хангахтай холбогдсон зүйл, заалтууд, агуулга, үзэл санаанд бүрэн нийцэх бөгөөд хуулийн төслийг дагалдуулан Орон сууцны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.